Монгол Улсынхаа төлөө зүтгэ!

# СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.04.15 №31 (31)

ЗАСГИЙН ГАЗАР

## ЗАСГИЙН ГАЗРЫН ЭЭЛЖИТ ХУРАЛДААН БОЛЛОО



Засгийн газрын өчигдрийн хуралдаанаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэснийг товчоор хүргэж байна.

-Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын Экспортын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд “Трактор, хөдөө аж ахуйн машин, агуулах нийлүүлэх төсөл”-ийн дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээг холбогдох хууль, журмын дагуу байгуулахыг ХХААХҮ-ийн сайдад даалгав.

-Монгол Улсын газрын нэгдмэл сангийн 2020 оны улсын нэгдсэн тайлан, Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын мэдээллийг тус тус сонсов.

-Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл, Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг тус тус хэлэлцэн дэмжээд УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.

-УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэнгийн санаачлан боловсруулсан “Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцээд төсөлд өгөх саналаа нэгтгэж санаачлагчид уламжлахаар тогтов.

ЦАГ АГААР

| | ӨДӨР | ШӨНӨ |
|---|---|---|
| УЛААНБААТАР | 0 | -8 |
| ӨМНӨД СУДАН | 36 | 24 |
| АФГАНИСТАН | 13 | 7 |

ВАЛЮТЫН ХАНШ

| ВАЛЮТ | АВАХ | ЗАРАХ |
|---|---|---|
| USD | 2.845.00 | 2.856.00 |
| EUR | 3.378.00 | 3.438.00 |
| CNY | 434.00 | 437.40 |
| RUB | 37.00 | 38.50 |
| JPY | 25.90 | 26.40 |
| KRW | 2.45 | 2.59 |

ҮЙЛ ЯВДАЛ

## АХЛАГЧИЙН АЛБАНЫХАН ТАЙЛАНГАА ЦАХИМААР ХЭЛЭЛЦЭВ



ЗХЖШ-ын ахлагч, тэргүүн ахлагч Б.Гантөмөр энэ сарын 14-нд Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлал, нэгтгэл, ангиудын даргалах албан тушаалын ахлагч нартай ахлагчийн албаны 2021 оны нэгдүгээр улирлын тайланг цахимаар хэлэлцэж, нэгдсэн мэдээлэл, зөвлөмжөөр хангалаа.

Хурлын эхэнд ЗХЖШ-ын даргын өгсөн үүргийн биелэлт, “Ахлагчийн албыг хөгжүүлэх хөтөлбөр-2021”, “Зэвсэгт хүчний ахлагчийн бүрэлдэхүүний бие бялдар, эрүүл мэндийг дээшлүүлэх жил”-ийн ажлын хэрэгжилт, цэргийн алба, сахилга, хариуцлагыг бэхжүүлэх хүрээнд хийж буй ажил, арга хэмжээний талаар тодруулсан. Мөн төрлийн цэргийн командлал, нэгтгэл, ангиудаас ахлагч болон тэдний гэр бүлтэй зохион байгуулж байгаа төлөвлөгөөт ажлын тайланг сонссон юм. Төгсгөлд нь сургалт бэлтгэл, эрүүл мэнд, бие бялдрын бэлтгэлжилт, цэргийн алба, сахилга, хариуцлага, нийгмийн хамгааллыг дээшлүүлэхэд онцгой анхаарч ажиллахыг даалгаад цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэхийг захилаа. Цэргийн хөдөлмөрийн гол баримтлах зарчим нь хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах гэдгийг ч тэрээр мөн сануулсан юм.

## ЦАГ АГААРЫН СЭРЭМЖЛҮҮЛЭГ

Өнөөдөр Архангай, Баянхонгор, Говьсүмбэр, Дорнод, Дорноговь, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Хэнтий, Хөвсгөл аймгийн нутгаар цас орно. Энэ үеэр салхины хурд, 18-20 м/с, түр зуур 26 м/с хүрч, цасан болон шороон шуурга шуурах тул иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллагуудыг болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхийг ОНЦГОЙЛОН анхааруулж байна.



ХИЛИЙН ЧАНАДААС

## ЭНХИЙГ САХИУЛАХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР САНАЛ СОЛИЛЦЛОО



БНӨСУ-д явагдаж байгаа НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны “Жуба” секторын командлагч, хурандаа Б.Эрдэнэбат нарын албаны хүмүүс иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажлын хүрээнд Жуба хотын Мунуки захын ойролцоо явагдсан орон нутгийн иргэдэд цэвэр ус түгээх ажилд биечлэн оролцлоо.



Тус хүмүүнлэгийн ажиллагааг Руанда улсын III батальоны цэргийн багаас зохион байгуулсан бөгөөд нутгийн удирдлага, иргэдийн талархлыг хүлээж чадсан юм. Мөн НҮБ-ын энхийг дэмжих ажиллагааны Хүчний штабын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, хүчний штабын ажиллагааны ахлах офицер, Руанда Улсын Зэвсэгт хүчний хурандаа Чансе Ндагано “Жуба” бүсийн штабт айлчиллаа. Энэ үеэр хурандаа Б.Эрдэнэбат БНӨСУ-д явагдаж буй энхийг сахиулах ажиллагааны талаар ярилцаж, туршлага солилцлоо.

**Хошууч Н.ГАНТУЛГА**

## ӨРНИЙН ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 3
2021.04.15.
/ПҮРЭВ ГАРАГ/

ХАВРЫН АДАГ ХАР ЛУУ САРЫН ГУРВАН ХӨХ ХАР ЛУУ ӨДӨР

Үс засуулбал: Эд мал баялаг төгөлдөр болно

Наран ургах, шингэх: 06.03-19.42

Барилдлага: Хүчин төгсөх

Шүтэн барилдлага: Хүрэлцэхүй

Суудал: Шороо.

*Аргын тооллын 4 дүгээр сарын 15, Бархасвадь гараг. Билгийн тооллын 3, Нэгэн эхийн зурхаан хөвгүүн одтой, харагчин могой өдөр. Өдрийн наран 6 цаг 03 минутад мандан, 19 цаг 42 минутад жаргана. Тухайн өдөр тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, хараал, жатгыг буцаах, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, буг дарах, газрын ам боохоод сайн. Ургаа мод таслах, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Модон хохимой өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд малтай баялаг төгс болно.*

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

| НИЙТ БҮРТГЭГДСЭН | ЭДГЭРСЭН | НАС БАРСАН |
|---|---|---|
| 16603+1220 | 9887+336 | 29/5 |

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

| НИЙТ БАТЛАГДСАН | ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ | ЭДГЭРСЭН |
|---|---|---|
| 1694 (7) | 302 | 1385 |

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 136,291,755

Эдгэрсэн
Нийт: 111,024,458

Нас барсан
Нийт: 2,941,128



ЦАХИМ ШУУДАНД

# АМЕРИКИЙН МОНГОЛ СУДЛАЛЫН ТӨВТЭЙ ХАМТАРЧ АЖИЛЛАНА

**ҮБХИС**

ҮБХИС-ийн багш, судлаачдын хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны царааг өргөжүүлэх зорилгоор АНУ-ын Монгол судлалын төвтэй хамтран ажиллах эхлэл болгон анхны цахим уулзалтыг зохион байгуулав.

Цахим уулзалтад Багшийн хөгжлийн төвийн дарга Г.Нандинцэцэг, профессор Я.Чойжамц, БХЭШХ-ийн дэд захирал, доктор (PhD), хурандаа Ж.Мэндээ, АНУ-ын Нью-Йорк хотноо төвтэй Монгол судлалын Америкийн төвийн гүйцэтгэх захирал, доктор М.Болорцэцэг, менежер Б.Байгальмаа нар оролцож санал солилцов. Уулзалтын эхэнд Монгол судлалын Америкийн төвийн гүйцэтгэх захирал М.Болорцэцэг төвийнхөө талаар товч танилцуулга хийсэн юм. Уг төв нь хоёр орны эрдэмтэн судлаачдын хамтын ажиллагааг дэмжих, Монгол судлалыг АНУ-д хөгжүүлэх, сургалт, судалгааны байгууллагуудыг холбоо тогтооход туслах, Монголын их, дээд сургуулиудын багш, судлаачдыг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх зорилгоор 2002 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа аж.




Профессор Я.Чойжамц мөн сургуулийнхаа талаар танилцуулга хийн, хоёр байгууллагын хамтран ажиллах боломжийн талаарх саналаа танилцуулав. Уулзалтын дунд ҮБХИС-ийн багш, судлаачдыг Монгол судлалын Америкийн төвөөс зохион байгуулдаг сургалт, бусад арга хэмжээнд оролцуулах, залуу судлаачдад зориулсан арга зүйн сургалт зохион байгуулах, менторшипын хөтөлбөрт хамруулах, судалгаа шинжилгээний бүтээлүүдийг гадаадын сэтгүүлд хэвлүүлэх боломжийг бүрдүүлэх, судлаач багш нар тус байгууллагын номын сангаар үйлчлүүлэх, АНУ-аас эрдэмтэн, судлаачдыг ҮБХИС-д урьж уулзалт хийлгэх, туршлага солилцох, монгол судлаачдын бүтээлийг сурталчлан таниулах, АНУ-ын их, дээд сургуулиудтай холбоо тогтоох зэрэг чиглэлээр хамтран ажиллах боломжтойг онцоллоо.

Хоёр байгууллага хамтын ажиллагааны санамж бичиг байгуулснаар дээрх саналууд хэрэгжих боломжтой юм. Монгол судлалын Америкийн төв ойрын хугацаанд хамтын ажиллагааны санамж бичгийн төслийг ирүүлэхээ мэдэгдэж, гэрээ батлагдмагц дээр тохиролцсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхлэхээ мэдэгдэв. Хоёр тал харилцан ойлголцох санамж бичгийг энэ сарын сүүлчээр байгуулахаар тохиролцлоо.




**Зэвсэгт хүчний 350 дугаар анги**

“Үндсэн салбарын жигдрэлт шат”-ны хээрийн гаралт, байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийг Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвийн районд зохион байгууллаа.

Энэ удаагийн хээрийн гаралтаар онолын мэдлэг, дадлагыг баталгаажуулах зорилгоор хичээлийн цэгийг дэлгэн хичээл сургуулийг цэргийн байр зүй, холбооны бэлтгэл, сэтгэл зүйн бэлтгэл, тактик, жагсаалын бэлтгэл, хүн эмнэлгийн бэлтгэл, химийн бэлтгэл, мэргэжлийн бэлтгэл зэрэг хичээлүүдийг хамруулав.

Тасгийн жигдрэлтийг хангах сургалтыг “Хүч нэмэгдүүлсэн мотобуудлагын тасаг давшилтад шилжих”, офицеруудтай штабын нэгдсэн дадлагыг “Мотобуудлагын батальон зах нийлсэн байдлаас байлдаан явуулах нь”, даргалах албан тушаалын ахлагч нартай “Мотобуудлагын рот явдлаас давшилтад шилжих нь” сэдвээр тус тус зохион байгуулсан юм. Мөн салааны байлдааны буудлагыг “Таван толгой”-н районд суурьт гранатомёт СПГ-9-ийн нэг, 82 мм-ийн миномётын нэг, хос голт төмөрт 23 мм-ийн зенитийн суурийн нэг тоотоор хүч нэмэгдүүлсэн “Мотобуудлагын салаа хориглосон дайсан руу явдлаас давших” сэдвээр, салааны шөнийн буудлагыг “Хүч нэмэгдүүлсэн мбс зах нийлээгүй үед хориглолтод шилжих, хориглолтыг шөнө явуулах” сэдвээр тус тус амжилттай явуулсан юм. Үүнээс гадна байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуульд оролцох алба хаагчдад “Айдас түгшүүр, сандралыг даван туулах”, “Нөхөртөө байлдааны талбарт тусламж үзүүлэх нь” сэдвээр сэтгэл зүйн бэлтгэл хичээлийг зохион явуулсан нь үр дүнтэй сургалт боллоо. Түүнчлэн бие бүрэлдэхүүний дунд гранат шидэлт, олс таталт, галын бэлтгэлийн норматив, гар барилдаан, саадын зурвас, гар дээр суниалт, ҮОХЗХБ-ийн нормативын тэмцээнүүдийг явуулав.



Мөн Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Гансэлэм, ЗХЖШ-ын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга, хурандаа Ш.Гантулга, Зэвсэгт хүчний 345 дугаар нэгтгэлийн захирагч, хурандаа Б.Хаш-Эрдэнэ нар хээрийн гаралтын сургалт бэлтгэл, буудлагын явцтай танилцсан юм.

**Ахмад Б.ДЭРДЭНЭНИНЖ**



# АХЛАГЧИД АЛБАА СУРТАЛЧИЛЛАА

**Зэвсэгт хүчний 013 дугаар анги**

“Ахлагчийн албыг хөгжүүлэх хөтөлбөр-2021”-ийн хүрээнд ЗХЖШ-ын даргын баталсан ахлагчийн албаны “Алсын хараа”, “Эрхэм зорилго”, “Үнэт зүйл”-ийг ангийн нийт ахлагчийн бүрэлдэхүүнд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулав.

Тус арга хэмжээг ангийн Ахлагчийн зөвлөлөөс цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан явууллаа.

**Сургагч ахлагч Д.НАСАНБАТ**

МЭРГЭЖИЛТЭН ЗӨВЛӨЖ БАЙНА

# ХЭЭРИЙН НӨХЦӨЛД КОРОНАВИРУСТ ХАЛДВАРААС ХАМГААЛАХ ХАЛДВАРГҮЙТГЭЛ, АРИУТГАЛЫН ЗААВАР

**Нэг. Ариутгал халдваргүйтгэлийн талаар**

***1.1. Шилжин байрлахаас өмнөх үеийн ариутгал халдваргүйтгэл***

-Халдваргүйжүүлэлт хийхдээ амны хаалт зүүх, нэг удаагийн халдвар хамгааллын хувцас өмсөх, ахуйн бээлий хэрэглэх;

-Голомтын эцсийн ариутгал хийх ажлын уусмал бэлтгэхдээ 10 литр усанд 7 ширхэг жавелион /0,1%/ шахмалаар хийж, паалантай болон хуванцар таглаатай саванд найруулна;

-Халдваргүйжүүлэлт хийхдээ дээрээс доош, гаднаас дотогш, цэвэр гадаргуугаас бохир гадаргуу, цэвэр орчноос бохир орчин гэсэн чиглэлээр, автомаксийн хошууг хамгийн бага дээр мананцар үүсгэж хийх;

-Агааржуулах хэсэг рүү халдваргүйжүүлэх уусмалыг хангалттай хэмжээгээр цацах;

-Халдваргүйжүүлэлт хийж байгаа үедээ тамхи татах, хоол идэх, шингэн уухыг хориглоно;

-Халдваргүйжүүлэх уусмалаар шүршиж халдваргүйжүүлэлт хийсэн үед халдваргүйжүүлэлтээс хойш 2 цагийн дараа агаар оруулж, чийгтэй цэвэрлэгээ хийнэ;

-Цэвэрлэгээнд хэрэглэсэн алчуур, хувин багаж хэрэгслийг 0,03 хувийн халдваргүйтгэх уусмалд 30 минут байлгасны дараа цэвэр усаар сайтар зайлж хатаана;

-Хэт мэдрэг, харшилтай хүн халдваргүйтгэлийн бодисыг болгоомжтой хэрэглэнэ;

-Халдваргүйжүүлэлтэд 2 өөр төрлийн бодисыг зэрэг хэрэглэхийг хориглоно.

***1.2.Өдөр тутмын ариутгал халдваргүйтгэл***

-Өдөр тутмын ариутгалыг 10 литр усанд 2 ширхэг жавелион /0,03%/ шахмалаар хийж, өдөр бүр шинээр найруулах;

- Ариутгал халдваргүйтгэлийг өдөрт 2-3 удаа тогтмол хийх;

-Гадаргуугийн ариутгалыг хүн бүр тогтмол хийх;

-Халдваргүйжүүлэлт хийхдээ дээрээс доош, гаднаас дотогш, цэвэр гадаргуугаас бохир гадаргуу, цэвэр орчноос бохир орчин чиглэлээр, автомаксийн хошууг хамгийн бага дээр мананцар үүсгэж хийх;

-Агааржуулах хэсэг рүү халдваргүйжүүлэх уусмалыг хангалттай хэмжээгээр цацах;

-Бие засах газар, ариун цэврийн өрөөнд гар халдваргүйжүүлэх уусмалыг тогтмол байрлуулах, сольж шинэчлэх, ариун цэврийн өрөөнд орсон тохиолдол бүрт цэргийн алба хаагчийн гарыг угаалгаж, ариутгаж хэвшүүлэх;

-Цэргийн байр, өрөө тасалгаанд чийгтэй цэвэрлэгээг тогтмол хийж, агаар сэлгэлтийг өдөрт 2-3 удаа хийж, хэт ягаан туяаны гэрэл (кварц), “виркон С” ариутгалын бодисоор агаарын ариутгалыг хийх;

-Цэргийн багийн бие бүрэлдэхүүнийг хооллохоос өмнө гарыг угаалгаж, амны хөндий, хоолойг давсны уусмал эсвэл тамединаар зайлуулж хэвшүүлэх;

-Бие бүрэлдэхүүнд амны хаалт хэрэглүүлэх, амны хаалтыг 2-3 цаг тутам солих.

**Хоёр. Баазын шалган нэвтрүүлэх цэгт хийх ариутгал, халдваргүйжүүлэлт**

-Шалган нэвтрүүлэх байранд ажиллах цэргийн алба хаагч амны хаалт тогтмол зүүж, нэг удаагийн бээлий өмссөн байх, амны хаалтыг 3 цаг тутам сольж, битүү таглаатай хогийн саванд хаяж, нэгдсэн устгалд оруулж хэвших;

-Чийгтэй цэвэрлэгээг өдөрт 3-аас доошгүй удаа хийж хэвших, цонх, шал, хаалганы бариул, хогийн сав гэх мэт хүний гар хүрэх бүх гадаргуун халдваргүйтгэлийн уусмалаар арчих, шүрших;

-Халдваргүйжүүлэлтийг шүршиж хийсэн тохиолдолд 1 цагийн дараа чийгтэй цэвэрлэгээг хийх;

-Цонхыг 2 цаг тутам нээж, агаар сэлгэлт хийх;

-Гар халдваргүйжүүлэх уусмалыг хүрэлцэхүйц хэмжээгээр байрлуулж, хэрэглээнд хяналт тавих.

**Гурав. Халдвараас урьдчилан сэргийлэх талаар хувь хүний зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

-Хүн бүр гаднаас орж ирэх, бие зассаны дараа, хоол унд бэлтгэх болон бэлтгэсний дараа, идэхийн өмнө гараа сайтар савандаж угаах, гар ариутгах уусмалыг тогтмол хэрэглэж хэвших;

-Хоолны хэрэгсэл аяга, таваг, халбага, сэрээг зориулалтын угаагч шингэн, 2 хувийн содын уусмалд угаах болон 30 минут буцалгаж хэрэглэх;

-Гадуур явахдаа амны хаалт тогтмол хэрэглэх, амны хаалтыг 2-3 цаг тутам сольж хэрэглэх;

-Гадуур хувцсыг тогтмол угааж хэрэглэх;

-Хүнтэй гар барихаас зайлсхийх;

-Нус, цэрээ ил задгай хаяхгүй байх;

-Ханиаж найтаах үед ам, хамрын алчуур, зориулалтын цаасаар ам хамраа таглах;

-Архи согтууруулах ундаа нь дархлааг бууруулдаг тул хэрэглэхгүй байх;

-Ажил амралтаа зохицуулах, дасгал хөдөлгөөн хийх.

-Цэргийн багийн бие бүрэлдэхүүний эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг сайжруулах чиглэлд төлөвлөгөө гарган мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавих.

**ЗХЖШ-ЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЭЛТЭС**

## ДАРААХ ШИНЖ ТЭМДГИЙН АЛЬ НЭГ ИЛЭРВЭЛ ЭМЧИД ЯАРАЛТАЙ ХАНДАНА УУ

-Биеийн халуун 38 хэмээс дээш болж халуурах;
-Ханиалгах, ханиалгалт нэмэгдэж байнгын болох;
-Биеийн бага зэргийн ачаалалд амьсгаадах (босож явах гэх мэт өдөр тутмын хийдэг үйлдлийг хийхэд);
-Ядарч сульдах;
-Олон удаа бөөлжих, суулгах;
-Тайван үед амьсгаадах, цээж давчдах;
-Цээжээр хөндүүр оргих, байнга өвдөх;
-Унтаа байдалд байх;
- Уруул, хумс, хурууны үзүүр хөхрөх.

СОЁМБО СОНИН
“Соёмбо” сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор Хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ

Эхийг “Соёмбо” сонины редакцад бэлтгэв.

*Зар, рекламыг хямд нийтэлнэ.
*Зар, рекламын үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сонины нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонины мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029